



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 11/150

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэгийн
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 3,129,600 /гурван сая нэг зуун хорин есөн мянга зургаан зуу/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг (А.Алтанзаяа)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг (А.Алтанзаяа)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

1119282495 115050000430

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
даргын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн
11/00 дугаар тушаалын хэвсрэлт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Тийлвэр рлэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	эх үүсвэр
1	Телевизор Led	Monel	40 инч	2019	шинэ	ш	2	459,900	919,800	Эцэг эхчүүд	Хандив
2	Телевизор	LGWP	40 инч	2019	шинэ	ш	1	430,000	430,000		
3	Тоос сорогч	Samsung	1800w	2020	шинэ	ш	1	289,900	289,900		
4	Тоос сорогч	FC-9350	1800w	2020	шинэ	ш	1	289,900	289,900		
Тоног төхөөрөмжийн дүн							5		1,929,600		
5	Ширээний теннисний ширээ	Хятад	1.5*2.75	2019	шинэ	ш	1	600,000	600,000	Өвөр монгол багш	Хандив
6	Дугуйлангийн тавиур	Монгол	Деспа хавтан	2019	шинэ	ш	1	600,000	600,000	Багш нар	
Тавилга эд хогшлын дүн							2		1,200,000		
Нийт бүртгэх хөрөнгийн дүн							7		3,129,600		